**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/158/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугээр сарын 20 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
Асуудлыг онцолсон хэсэг ........ **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал ........ **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 10
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 14
4.1 Ерөнхий зүйл ........ 14
4.2 Материаллаг байдал ........ 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
5.1 Төлбөрийн акт ........ 16
5.3 Зөвлөмж ........ 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/68

танай ______________ -ны №______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТЭМҮЖИН ТЕАТРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Ж.БАТБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 20,393.2 мянган төгрөгийн 14 гүйлгээний анхан шатны баримтад и-баримтыг хавсаргаагүй, цахим төлбөрийн баримтын системд мэдээлээгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

005020304

D/2023-A4 Alban toot

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **88,175,017.00** | **121,118,405.54** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 16,667,288.54 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 16,667,288.54 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 16,667,288.54 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 16,667,288.54 |
| **33** | **АВЛАГА** | 427,133.00 | 427,133.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 427,133.00 | 427,133.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 87,747,884.00 | 104,023,984.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,099,190.00 | 6,099,190.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,099,190.00 | 6,099,190.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 81,648,694.00 | 97,924,794.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 92,100.00 | 92,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,103,100.00 | 5,103,100.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 240,000.00 | 240,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 76,213,494.00 | 92,489,594.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **35,924,751.84** | **75,534,694.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 35,924,751.84 | 75,534,694.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 30,163,651.84 | 59,298,594.16 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 9,791,666.00 | 9,791,666.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -815,972.16 | -3,263,888.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 96,096,551.00 | 136,515,451.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -87,261,562.84 | -99,084,070.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,149,396.00 | 119,539,396.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -100,551,826.16 | -106,096,959.69 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,474,500.00 | 2,474,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,524,100.00 | -1,682,500.00 |
| 39217 | Ном | 805,000.00 | 1,105,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,761,100.00 | 16,236,100.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 2,050,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -575,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,761,100.00 | 14,761,100.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **124,099,768.84** | **196,653,099.70** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,746,805.13** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,746,805.13 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 5,746,805.13 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,746,805.13 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭ ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **118,352,963.71** | **196,653,099.70** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 118,352,963.71 | 196,653,099.70 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 137,949,437.69 | 137,949,437.69 |
| 51101 | Өмч: - төрийн | 137,949,437.69 | 137,949,437.69 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -42,697,834.98 | 35,602,301.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -42,697,834.98 | -42,697,834.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 78,300,135.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 23,101,361.00 | 23,101,361.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **124,099,768.84** | **196,653,099.70** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **475,829,376.00** | **546,999,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,791,666.00** | **34,139,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,791,666.00 | 34,139,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,791,666.00 | 5,639,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,639,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,791,666.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **466,037,710.00** | **512,860,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,721,310.00 | 1,160,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,721,310.00 | 1,160,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 460,316,400.00 | 99,274,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 460,316,400.00 | 99,274,600.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 412,425,500.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 412,425,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **471,534,979.98** | **468,699,464.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **471,534,979.98** | **468,699,464.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 434,653,359.98 | 465,023,112.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 288,657,055.00 | 281,380,908.00 |
| 210101 | Үндсэн цалин | 288,657,055.00 | 281,380,908.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,900,850.13 | 34,764,318.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,900,850.13 | 34,764,318.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 78,750,749.00 | 84,848,248.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,882,591.00 | 2,178,198.00 |
| 210302 | Түлш, халаалт | 70,796,510.00 | 74,304,446.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,071,648.00 | 8,365,604.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,213,151.00 | 5,902,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,830,060.00 | 1,689,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,618,000.00 | 2,618,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 512,431.00 | 439,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 952,660.00 | 956,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 450,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 450,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 | 5,850,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 2,050,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 3,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 999,000.00 | 2,160,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 426,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 999,000.00 | 1,734,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,248,400.00 | 12,446,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,700,400.00 | 12,446,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 198,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,434,154.85 | 37,670,537.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,468,950.00 | 17,671,580.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 8,965,204.85 | 19,998,957.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,881,620.00 | 3,676,352.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,019,300.00 | 1,268,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,019,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,268,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 862,320.00 | 2,408,352.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 841,010.00 | 2,408,352.00 |
| 213404 | Хөрөнгийн | 21,310.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,294,396.02** | **78,300,135.99** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,294,396.02** | **78,300,135.99** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **466,037,710.00** | **518,499,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **5,639,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 5,639,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 5,639,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,639,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **466,037,710.00** | **512,860,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,721,310.00 | 1,160,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,721,310.00 | 1,160,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 460,316,400.00 | 99,274,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 460,316,400.00 | 99,274,600.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 412,425,500.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 412,425,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **458,428,410.00** | **470,723,411.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **458,428,410.00** | **470,723,411.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **421,546,790.00** | **467,047,059.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,772,000.00 | 285,918,784.00 |
| 210101 | Үндсэн цалин | 281,772,000.00 | 244,521,145.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 23,515,262.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 10,577,577.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 7,304,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,039,100.00 | 35,973,247.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,768,300.00 | 25,579,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817,700.00 | 2,494,903.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,254,200.00 | 1,745,129.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 563,500.00 | 241,469.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,635,400.00 | 5,912,646.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 78,750,749.00 | 84,848,248.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,330,623.00 | 2,178,198.00 |
| 210302 | Түлш, халаалт | 70,796,510.00 | 74,304,446.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,623,616.00 | 8,365,604.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,897,691.00 | 5,902,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,544,060.00 | 1,546,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,618,000.00 | 2,618,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 479,431.00 | 481,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 956,200.00 | 956,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 450,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 450,000.00 | 450,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 | 6,300,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 2,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 3,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 999,000.00 | 1,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 999,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,248,000.00 | 26,805,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,700,000.00 | 26,805,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 198,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,390,250.00 | 19,848,580.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,390,250.00 | 19,848,580.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,881,620.00** | **3,676,352.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,019,300.00 | 1,268,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,019,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,268,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 862,320.00 | 2,408,352.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 841,010.00 | 2,408,352.00 |
| 213404 | Хөрөнгийн | 21,310.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,609,300.00** | **47,776,188.54** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,609,300.00** | **31,108,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,609,300.00** | **31,108,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,609,300.00 | 31,108,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,609,300.00 | 31,108,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,609,300.00** | **-31,108,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 16,667,288.54 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 16,667,288.54 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 137,949,437.69 | 23,101,361.00 | -46,789,837.68 | 114,260,961.01 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| С03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **137,949,437.69** | **23,101,361.00** | **-46,789,837.68** | 114,260,961.01 |
| С07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -946,053.37 | -946,053.37 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **137,949,437.69** | **23,101,361.00** | **-42,697,834.98** | 118,352,963.71 |
| D01 | **2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **137,949,437.69** | **23,101,361.00** | **-42,697,834.98** | 118,352,963.71 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **137,949,437.69** | **23,101,361.00** | **-42,697,834.98** | 118,352,963.71 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 78,300,135.99 | 78,300,135.99 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **137,949,437.69** | **23,101,361.00** | **35,602,301.01** | 196,653,099.70 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 517,339,600.00 | 498,263,959.46 | 19,075,640.54 | 96.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 517,339,600.00 | 498,263,959.46 | 19,075,640.54 | 96.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 516,071,600.00 | 496,995,959.64 | 19,075,640.36 | 96.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 300,931,300.00 | 285,918,784.00 | 15,012,516.00 | 95.0 |
| 210101 | Үндсэн цалин | 276,124,600.00 | 244,521,145.00 | 31,603,455.00 | 88.6 |
| 210102 | Нэмэгдэл | 17,501,900.00 | 23,515,262.00 | -6,013,362.00 | 134.4 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 10,577,577.00 | - 10,577,577.00 | #DIV/0! |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,304,800.00 | 7,304,800.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,616,600.00 | 35,973,247.46 | 1,643,352.54 | 95.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,579,100.00 | 25,579,100.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,009,500.00 | 2,494,903.00 | 514,597.00 | 82.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,407,400.00 | 1,745,129.29 | 662,270.71 | 72.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 602,100.00 | 241,469.17 | 360,630.83 | 40.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,018,500.00 | 5,912,646.00 | 105,854.00 | 98.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 87,256,600.00 | 84,848,248.00 | 2,408,352.00 | 97.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,900,000.00 | 2,178,198.00 | 1,721,802.00 | 55.9 |
| 210302 | Түлш, халаалт | 75,854,000.00 | 74,304,446.00 | 1,549,554.00 | 98.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,502,600.00 | 8,356,604.00 | -854,004.00 | 111.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,902,400.00 | 5,902,400.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,544,200.00 | 1,546,300.00 | -2,100.00 | 100.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,618,000.00 | 2,618,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 484,000.00 | 481,900.00 | 2,100.00 | 99.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 956,200.00 | 956,200.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,300,000.00 | 6,300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,800,000.00 | 3,800,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 47,614,700.00 | 47,614,700.00 | 0.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,614,700.00 | 47,614,700.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29000000.00 | 28988580.00 | 11,420.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,000,000.00 | 28,988,580.00 | 11,420.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1268000.00 | 1268000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,268,000.00 | 1,268,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,268,000.00 | 1,268,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 517,339,600.00 | 514,931,248.00 | 2,408,352.00 | 99.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 412,425,500.00 | 412,425,500.00 | 0.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 412,425,500.00 | 412,425,500.00 | 0.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 99,274,600.00 | 96,866,248.00 | 2,408,352.00 | 97.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 99,274,600.00 | 96,866,248.00 | 2,408,352.00 | 97.6 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,639,500.00 | 5,639,500.00 | 0.00 | 100.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,639,500.00 | 5,639,500.00 | 0.00 | 100.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 16,667,288.54 | -16,667,288.54 | #DIV/0! |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26 | 26 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26** | **26** | 0.00 | 100.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 18 | 18 | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 | 0.00 | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/мянган төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,700,000.00** | **1,160,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,700,000.00** | **1,160,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,700,000.00 | 1,160,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** | **-** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр нь Сургалт, уран бүтээлийн үйл ажиллагаа явуулах зорилго дэвшүүлэн, Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчин, технологийн шинэчлэлтэд тулгуурлаж үзэгчид, суралцагч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх мэргэжлийн чиг баримжаа олгож тэдэнд урлагийн боловсролоор

дамжуулан хүүхдийн бахархалт бүтээлийг бий болгох, орчин үеийн болон сонгодог ардын өв соёл биет болон биет бус өвийг өвлүүлэх уран бүтээлийг нийтэд дэлгэрүүлэх зорилт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийн үүргийг Соёлын яамны дотоод аудитын нэгж хэрэгжүүлэх ба Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 196,653.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 72,553.3 мянган төгрөгөөр буюу 58.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 16,667.3 | 16,667.3 |
| Авлага | 427.1 | 427.1 | - |
| Бараа материал | 87,747.9 | 104,024.0 | 16,276.1 |
| Үндсэн хөрөнгө | 226,628.2 | 286,237.1 | 59,608.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (190,703.5) | (210,702.4) | (19,999.0) |
| **Нийт хөрөнгө** | **124,099.8** | **196,653.1** | 72,553.3 |
| Өр төлбөр | 5,746.8 | | (5,746.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 118,353.0 | 196,653.1 | 78,300.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **124,099.8** | **196,653.1** | **72,553.3** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант оны эцэст улсын төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 16,667.3 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 427.1 мянган төгрөг үлдэгдэлтэй бөгөөд тайлант өөрчлөлт ороогүй бөгөөд тухай авлага нь 2016 онд үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 104,024.0 мянган төгрөг болж өмнөх оноос 16,276.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 36,354.4 мянга, 20,078.3 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой бөгөөд бусад хангамжийн материал 16,276.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 286,237.1 мянган төгрөг болж 61,665.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31,108.9 мянга, Соёлын яамнаас 28,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 196,653.1 мянган төгрөг болж 78,300.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 78,300.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 687,494.5 мянга, нийт зарлагыг 687,494.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 197,474.4 мянган төгрөгөөр бууруулж 490,020.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 517,339.6 мянган төгрөг болгож 27,319.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702 хөтөлбөрийн 80101, 80214, 80802, 81941, 83603 арга хэмжээг санхүүжүүлэхээр 517,339.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 412,425.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 99,274.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,639.5 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 412,425.5 мянга, орон нутгийн төсвөөс 99,274.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй орон нутгийн төсвийн санхүүжилтээс 2,408.4 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 498,264.0 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 19,075.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| 2 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 371,657.5 | 354,990.2 | 16,667.3 | 95.5 |
| 3 | 80214 Уран бүтээл хийлгэх | 40,000.0 | 40,000.0 | 0.0 | 100.0 |
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 768.0 | 768.0 | 0.0 | 100.0 |
| 5 | 83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан | 5,639.5 | 5,639.5 | 0.0 | 100.0 |
| 6 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 99,274.6 | 96,866.2 | 2,408.4 | 97.6 |
| | **Нийт дүн** | **517,339.6** | **498,264.0** | **19,075.6** | 96.3 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй бөгөөд тайлант онд 100030035405 тоот дансанд 1,160.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төг/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Заалны орлого | 1,160.0 |
| | Нийт орлогын дүн | 1,160.0 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын дарга Ж.Батболд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч М.Мөнхбат нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 517,339.6 мянган төгрөгөөс тооцоход 7,760.1 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 5,432.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд шилэн дансны цахим системд 626,301.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл оруулж 3 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна. Харин Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 10906.9 мянга, зарлагын 8 гүйлгээний 67,138.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

*Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлэвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 95 | 1 | |
| | Нийт | 27 | 151 | 146 | 3 | 2 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлэв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн аудитын 6,193.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 15,136.0 мянган

төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2022.05.30-ны өдрийн 40 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 5 | 21,329.8 | 5 | 21,329.8 | 100 |
| **Нийт дүн** | 5 | 21,329.8 | 5 | 21,329.8 | 100 |

Эх сурвалж: 2021 оны аудитын тайлангаас

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,530.3 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 2,103.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 427.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 20,393.2 мянган төгрөгийн 14 гүйлгээний анхан шатны баримтад и-баримтыг хавсаргаагүй, цахим төлбөрийн баримтын системд мэдээлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

**Шийдвэрлэсэн нь**: Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүсээс суутган тооцоо хийж 2,039.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов

2. Тус байгууллагын дарга Ж.Батболд 2022.03.30-2022.04.02-ны хооронд Улаанбаатар хотод ажилласан байтал нягтлан бодогч 7 хоногоор томилолт бодож 64.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2 дугаар зүйлийн 2.4-т “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Илүү олгосон 64.0 мянган төгрөгийн албан томилолтыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.3 Зөвлөмж

1. Тухайн байгууллагын оны эхэнд ажиллагсадтай холбоотой авлагын үлдэгдэл 427.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд оны эцэст барагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна." гэсэн заалтууд санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” , “Үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Дансанд бүртгэлтэй олон жилийн насжилтай 427.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч цаашид өглөг, авлага үүсгэхгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх актын төлбөрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа ажил үйлчилгээний 14 гүйлгээний анхан шатны баримтад И-баримт хавсаргаагүй, цахим төлбөрийн баримтын системд мэдээлээгүй байна. | 1 | 2,039.3 | 1 | 2,039.3 | | | | |
| Томилолтын зардлыг 64.0 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна. | 1 | 64.0 | 1 | 64.0 | | | | |
| Тухайн байгууллагын оны эхэнд ажиллагсадтай холбоотой авлагын үлдэгдэл 427.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд оны эцэст барагдаагүй байна. | 1 | 427.1 | | | | | 1 | 427.1 |
| Дүн | 3 | 2,530.4 | 2 | 2,103.3 | - | - | 1 | 427.1 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><td rowspan="3">Зөрчлийн товч утга</td><td colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</td><td colspan="6">Үүнээс</td></tr>
<tr><td colspan="2">Төлбөрийн акт</td><td colspan="2">Албан шаардлага</td><td colspan="2">Зөвлөмж</td></tr>
<tr><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td></tr>
<tr><td colspan="9">Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</td></tr>
<tr><td>Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 10906.9 мянга, зарлагын 8 гүйлгээний 67,138.4 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.</td><td>1</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>1</td><td>0</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td>Дүн</td><td>1</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>1</td><td>0</td></tr>
<tr><td colspan="9">Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>1</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>1</td><td>0</td></tr>
</table>

ooOoo